



Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2023 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн  
А/191 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АВТОМАШИН, ТЕХНИКИЙН ТУСГАЙ ТОНОГЛОЛ,  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ ХЭРЭГСЛИЙГ ТУРШИН ШАЛГАХ,  
ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврын зорилго нь Галын аюулгүй байдлын тухай хуульд заасан гал түймэр унтраах, авран хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд гал түймэр унтраах автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдал, алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад оршино.

1.2. Энэхүү зааврыг Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа гал түймэр унтраах автомашин, техникийн тусгай тоноглол, гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хэвийн ажиллагааг туршин шалгах, техникийн үйлчилгээ (цаашид “туршин шалгах, техникийн үйлчилгээ” гэх)-г зохион байгуулах үед мөрдөнө.

Хоёр. Туршин шалгах ажлын зохион байгуулалт

2.1. Туршин шалгах ажлыг гүйцэтгэх алба хаагч хамгаалах тусгай хувцас, хэрэгслийг бүрэн өмссөн байна;

2.2. Туршин шалгах ажлыг албаны бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр зохион байгуулна;

2.3. Туршин шалгах ажлыг гүйцэтгэх үед Гал түймэр унтраах дүрэм, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм болон бусад холбогдох дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллана;

2.4. Туршин шалгах ажлыг тухайн автомашин, техник, тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ажиллуулах сургалт, дадлагад хамрагдаж, мэдлэг, чадвар эзэмшсэн 3-аас доошгүй алба хаагч хийж гүйцэтгэнэ;

2.5. Туршин шалгах ажлыг гал түймэр унтраах, аврах анги, салбарын захирагч удирдлага зохицуулалтаар хангаж, хяналт тавих ба техник, тоног төхөөрөмж хариуцсан албан тушаалтан, салааны захирагч, бүлгийн дарга нар хариуцан зохион байгуулна.

2.6. Туршин шалгах ажлыг энэхүү зааврын хоёрдугаар хавсралтад заасны дагуу хийж гүйцэтгэнэ;

2.7. Туршин шалгахад шаардлага хангаагүй тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг томилгоот ээлжийн хуваариас хасаж, гал түймэр унтраах, аврах анги (салбар)-ийн захирагч (дарга)-д танилцуулан, нэн даруй засварлах ажлыг техник, тоног төхөөрөмж хариуцсан албан тушаалтан хариуцан зохион байгуулна;

2.8. Туршин шалгахад шаардлага хангаагүй тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг томилгоот ээлжийн хуваариас хасах тохиолдолд хэвийн ажиллагаатай тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг сольж хуваарьт оруулна.



2.9. Туршин шалгах ажлыг зохион байгуулсан даруйд туршин шалгасан акт (гуравдугаар хавсралт), хувийн дэвтэрт тэмдэглэл үйлдэж баталгаажуулна;

2.10. Туршин шалгасан акт, хувийн дэвтэрт тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нэр, загвар, хувийн дугаар (давтагдахгүй серийн дугаар)-аар бүртгэж тэмдэглэнэ;

2.11. Гал түймэр унтраах, аврах анги (салбар)-ийн өдөр тутмын дадлага, сургалтын цагаар туршин шалгах ажлыг зохион байгуулж болно.

2.12. Туршин шалгахад шаардлага хангаагүй, засварлах боломжгүй тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг данснаас хасуулах ажлыг холбогдох комисс зохион байгуулна.

2.13. Энэхүү зааварт тусгагдсан туршин шалгах ажиллагаа нь ажиллагааны өмнөх шалгалт болон бусад дүрэм, журамд заагдсан шалгалтуудыг хийхгүй байх үндэслэл болохгүй.

### Гурав. Техникийн үйлчилгээ хийх ажлын зохион байгуулалт

3.1. Техникийн үйлчилгээ хийх алба хаагч зориулалтын ажлын хувцсыг бүрэн өмссөн, хамгаалах хэрэгсэл, зориулалтын багаж хэрэгсэлтэй байна;

3.2. Техникийн үйлчилгээ хийх ажлыг албаны бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр зохион байгуулна;

3.3. Техникийн үйлчилгээ хийх ажлыг гүйцэтгэх алба хаагч хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангасан байна;

3.4. Техникийн үйлчилгээ хийх ажлыг тухайн автомашин, техник, тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг ажиллуулах, үйлчилгээ хийх сургалт, дадлагад хамрагдаж, мэдлэг, чадвар эзэмшсэн алба хаагч хийж гүйцэтгэнэ;

3.5. Техникийн үйлчилгээ хийх ажлыг энэхүү зааврын хоёрдугаар хавсралтад заасан хугацаанд хийж гүйцэтгэнэ;

3.6. Техникийн үйлчилгээ хийх ажлыг автомашин, техник, тоног төхөөрөмж хариуцсан албан тушаалтан хариуцан зохион байгуулж, гал түймэр унтраах, аврах анги (салбар)-ийн захирагч (дарга) хяналт тавина.

3.7. Тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд техникийн үйлчилгээ хийсэн мэдээллийг тухай бүрт хувийн дугаар (давтагдахгүй серийн дугаар) бүхий хувийн дэвтэр (техникийн паспорт)-т тэмдэглэнэ.

3.8. Удаан хугацаагаар техникийн үйлчилгээ хийх шаардлагатай тохиолдолд хэвийн ажиллагаатай автомашин, техник, тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг сольж хуваарьт оруулна.

3.9. Зайлшгүй шаардлагаар томилгоот хуваариас хасах үед нөхөж хуваарьт оруулах техник, тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл байхгүй тохиолдолд харьяа газар, хэлтсийн даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.

3.10. Техникийн үйлчилгээ хийхдээ зөвхөн үйлдвэрлэгчээс тогтоосон загвар (төрөл)-ын тос, тослох материал, цэвэрлэгээний бодисыг хэрэглэнэ.

3.11. Гал түймэр унтраах автомашин, техникийн арал (шасси), явах эд ангитай холбоотой техникийн үйлчилгээг холбогдох журам, зааврын дагуу хийж гүйцэтгэнэ.

## Дөрөв. Бусад

4.1. Техникийн үйлчилгээ, засвар хийсэн тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг туршин шалгаж, зүгшрүүлэлт хийсний дараа томилгоот хуваарьт оруулна.

4.2. Туршин шалгах, техникийн үйлчилгээ хийх нэгдсэн график төлөвлөгөөг техник, тоног төхөөрөмж хариуцсан албан тушаалтан хагас, бүтэн жилээр гаргаж шууд захирагч даргаар батлуулна.

4.3. Гал түймэр унтраах автомашин, техник, гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэгчээс туршин шалгах, техникийн үйлчилгээ хийх зааврыг тусгайлан гаргасан тохиолдолд үйлдвэрлэгчийн зааврыг нэгэн адил (ажил давхардуулахгүйгээр) дагаж мөрдөнө.

4.4. Гал түймэр унтраах автомашин, техникийн тусгай тоноглол, гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хэвийн ажиллагааг туршин шалгасан, техникийн үйлчилгээ хийсэн талаар техник, тоног төхөөрөмж хариуцсан албан тушаалтан Онцгой байдлын газар, хэлтсийн даргад тухай бүрт танилцуулж, улирал бүр тайлагнана.

---oOo---



Онцгой байдлын ерөнхий газрын дархын  
 2023 оны 6 дугаар сарын 6 ны өдрийн  
 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт  
 ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АВТОМАШИН, ТЕХНИКИЙН ТУСГАЙ ТОНОГЛОЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ,  
 БАГАЖ ХЭРЭГСЛИЙГ ТУРШИН ШАЛГАХ, ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ХУГАЦАА,  
 АРГАЧЛАЛ, ХАРИУЦАХ АЛБАН ТУШААЛТАН



| № | Туршин шалгах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр | Туршин шалгах         |            |                               |                               | Техникийн үйлчилгээ                               |                               |  |                               |   |  |
|---|---|-----------------------|------------|-------------------------------|-------------------------------|---|-------------------------------|--|-------------------------------|---|--|
|   |   | Туршин шалгах хугацаа |            | Туршин шалгах албан тушаалтан | Хяналт тавих албан тушаалт ан | Техникийн үйлчилгээ хийх хугацаа                  |                               | Техникийн үйлчилгээ хийх албан тушаалтан | Хяналт тавих албан тушаалт ан | Техникийн үйлчилгээ хийх аргачлал, заавар |  |
| 1 | Гал унтраах хөөрөг /насос/*                         | Сар бүр               | Улирал бүр | Хагас жил бүр                 | Жил бүр                       | Техник, тоног төхөөрөмж хариуцсан албан тушаалтан | Гал унтраах автомашины жолооч | Аврагч, гал сөнөөгч                      | Ангийн захирагч               | Салааны захирагч                          | Гал түймэр унтраах автомашин, техникийн гал унтраах усны хөөрөг /насос/-ийг туршин шалгах аас өмнө автомашин, техникийн агрегат /хөдөлгүүр, хурдны хайрцаг болон бусад эд анги-ын хэвийн ажиллагааг урьдчилан шалгана;<br>2. Гал түймэр унтраах автомашин, техникийн гал унтраах усны хөөрөг /насос/-ийг |
|   |   | Сар бүр               | Улирал бүр | Хагас жил бүр                 | Жил бүр                       | Техник, тоног төхөөрөмж хариуцсан албан тушаалтан | Гал унтраах автомашины жолооч | Аврагч, гал сөнөөгч                      | Ангийн захирагч               | Салааны захирагч                          | Гал түймэр унтраах автомашин, техникийн үйлдвэрлэлийн гарын авлагад заасны дагуу хийж үйлдэгэнэ.<br>1. Хөөрөгний дамжуулагч ременийг шалгаж, шаардлагатай тохиолдолд чангалах, солих;<br>2. Хөөрөгний дамжуулагч эд анги,  |

ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ АВТОМАШИН, ТЕХНИКИЙН ТУСГАЙ ТОНОГЛОЛ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖ ХЭРЭГСЛИЙГ ТУРШИН ШАЛГАХ, ТЕХНИКИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ХУГАЦАА, АРГАЧЛАЛ, ХАРИУЦАХ АЛБАН ТУШААЛТАН

| № | Туршин шалгах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр       | Туршин шалгах         |            |               |         |   |                               |                     |                              | Техникийн үйлчилгээ  |                  |         |            |  |         |   |                              |                               |                     |                 |                  |  |  |  |  |  |
|---|---|-----------------------|------------|---------------|---------|---|-------------------------------|---------------------|------------------------------|--|------------------|---------|------------|--|---------|---|------------------------------|-------------------------------|---------------------|-----------------|------------------|--|--|--|--|--|
|   |   | Туршин шалгах хугацаа |            |               |         | Туршин шалгах албан тушаалтан                     |                               |                     | Хяналт тавих албан тушаалтан | Техникийн үйлчилгээ хийх хугацаа   |                  |         |            | Техникийн үйлчилгээ хийх албан тушаалтан |         |   | Хяналт тавих албан тушаалтан |                               |                     |                 |                  |  |  |  |  |  |
|   |   | Сар бүр               | Улирал бүр | Хагас жил бүр | Жил бүр | Техник, тоног төхөөрөмж хариуцсан албан тушаалтан | Гал унтраах автомашины жолооч | Авралч, гал сөнөөгч |                              | Ангийн захиралч  | Салааны захиралч | Сар бүр | Улирал бүр | Хагас жил бүр                            | Жил бүр | Техник, тоног төхөөрөмж хариуцсан албан тушаалтан |                              | Гал унтраах автомашины жолооч | Авралч, гал сөнөөгч | Ангийн захиралч | Салааны захиралч |  |  |  |  |  |
| 1 | Гал унтраах хөөрөг /насос/*                               | •                     |            |               |         | •   | •                             | •                   |                              | 1. Гал түймэр унтраах автомашин, техникийн гал унтраах усны хөөрөг /насос/-ийг туршин шалгахдаас өмнө автомашин, техникийн аргаргаг /хөдөлгүүр, хурдны хайрцаг болон бусад эд анги/-ын хэвийн ажиллагааг урьдчилан шалгана;<br>2. Гал түймэр унтраах автомашин, техникийн гал унтраах усны хөөрөг /насос/-ийг үйлдвэрлэлчээс заасан дээд хүчин чадлын 60-аас 80 хувьтай тэнцэх хүчин чадлаар 1 минутаас багагүй хугацаанд ажиллуулан шалгана /соролт болон шахал/<br>3. Гал түймэр унтраах автомашин, техникийн гал унтраах хөөсний хөөрөг /насос/-ийг хушуугаар хөөсний холимог гаргаж ажиллуулан шалгана;<br>4. Гал түймэр унтраах автомашин, техникийн гал унтраах усны хөөрөг /насос/-ийг туршин шалгахад дагалдах тоног төхөөрөмж буюу нэмэлт халаагуур, үндсэн болон нөөц удирдлага зэргийг ажиллуулж шалгана;<br>5. Гал түймэр унтраах автомашин, техникийн гал унтраах хөөрөг /насос/-ийг туршин шалгасны дараа хөөрөгний дундын холболтууд, жийргээр ус, хөөс үүсгэгч гоожсон эсэхийг шалгана;<br>6. Гал түймэр унтраах автомашин, техникийн гал унтраах хөөрөг /насос/-ний орох, гарах хавхлагын хаалт, хаалтын мэдрэгч, жийрэг, холболтуудыг шалгана;<br>7. Хөөрөгний редукторын тосны түвшинг шалгана. |                  |         |            |  |         |   |                              |                               |                     |                 |                  |  |  |  |  | Гал түймэр унтраах автомашин, техникийн үйлдвэрлэгчийн гарын авлагад заасны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:<br>1. Хөөрөгний дамжуулагч ременийг шалгаж, шаардлагатай тохиолдолд чангалах, солих;<br>2. Хөөрөгний дамжуулагч эд анги, эргэх холхивчуудыг тослох;<br>3. Хөөрөг, редукторын тос (масло)-ыг 6 сар тутам (50 цаг ажилласан тутамд)-д солих;<br>4. Хөөрөг /насос/-ний нэмэлт халаагуурын тосыг солих;<br>5. Хөөрөг /насос/-ний орох, гарах хавхлагын хаалт, холболтуудад тосолгоо хийх. |
| 2 | Гал унтраах бодис /ус, хөөс үүсгэгч, нунтаг/-ын сав*      |                       |            |               |         | •   | •                             | •                   |                              | 1. Гал унтраах бодисын савыг шалгахдаа автомашины арал, сууринд бэхлэгдсэн бэхлэгээг шалгана;<br>2. Гал унтраах бодисын савыг хоослон цалгилтын эсрэг хаалтыг шалгана;<br>3. Гал унтраах бодисын савны илүүдлийн хаалтыг шалгана;<br>4. Гал унтраах бодисын савны түвшин хэмжигчийн ажиллагааг шалгана;<br>5. Гал унтраах бодисын сав халаагчийн ажиллагааг шалгана;<br>6. Гал унтраах бодисын савны орох, гарах хавхлагын хаалт, жийрэг, холболтуудыг шалгана;<br>7. Гал унтраах бодисын савны нээлхий /люк/-ний таг, жийрэг, түгжээг шалгана;<br>8. Гал унтраах бодисын савны бүрэн бүтэн байдлыг шалгана.   |                  |         |            |  |         |   |                              |                               |                     |                 |                  |  | Гал түймэр унтраах автомашин, техникийн үйлдвэрлэгчийн гарын авлагад заасны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:<br>1. Гал унтраах бодисын савны арал, сууринд бэхлэгдсэн бэхлэгээ, жийргэвчийг тослох;<br>2. Гал унтраах бодисын савны дотор тал, юулах хаалт, шүүрийг цэвэрлэх;<br>3. Гал унтраах бодисын савны нээлхий /люк/-ний таг, жийрэг, түгжээг тослох;<br>4. Гал унтраах бодисын савны бэхлэгээг чангалах. |  |  |  |
| 3 | Суурин лафетны хушуу*                                     | •                     |            |               |         |   |                               | •                   |                              | 1. Лафетны хушууны автомашинд бэхлэгдсэн бэхлэгээг шалгана;<br>2. Лафетны хушуунд хагарсан, цуурсан гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана;<br>3. Лафетны хушууны эргэх хэсгүүдийн хөдөлгөөн, жийрэг резинүүдийн битүүмжлэл, түгжээг шалгана;<br>4. Лафетны хушууны даралт хэмжигч, зарцуулалт болон гаралтын төрөл тохируулагчийн ажиллагааг шалгана;<br>5. Алсын болон бүхээгийн удирдлагын ажиллагааг шалгана;<br>6. Лафетны хушууг техникийн үзүүлэлтэд заасан ажлын дундаж даралтаар 1 минутаас багагүй хугацаанд ажиллуулж шалгана. (Ажлын даралт дунджаар 6-10 бар)   |                  |         |            |  |         |   |                              |                               |                     |                 |                  |  |  | 1. Лафетны хушууны эргэх холхивч, хаалтуудыг тослох;<br>2. Лафетны хушууны бэхлэгээ, түгжээний бэхлэгээг чангалах;<br>3. Лафетны хушууны зарцуулалт болон гаралтын төрөл тохируулагч зэрэг хөдөлгөөнт хэсгүүдийг цэвэрлэж, тослох. |  |  |
| 4 | Зөөврийн лафетны хушуу                                    | •                     |            |               |         |   |                               | •                   |                              | 1. Лафетны хушууны суурийн бүрэн бүтэн байдал, бэхлэгээг шалгана;<br>2. Лафетны хушуунд хагарсан, цуурсан гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана;<br>3. Лафетны хушууны эргэх хэсгүүдийн хөдөлгөөн, жийрэг резинүүдийн битүүмжлэл, түгжээг шалгана;<br>4. Лафетны хушууны даралт хэмжигч, зарцуулалт болон гаралтын төрөл тохируулагчийн ажиллагааг шалгана;<br>5. Лафетны хушууг техникийн үзүүлэлтэд заасан ажлын дундаж даралтаар 1 минутаас багагүй хугацаанд ажиллуулж шалгана. (Ажлын даралт дунджаар 6-10 бар)  |                  |         |            |  |         |   |                              |                               |                     |                 |                  |  |  | 1. Лафетны хушууны эргэх холхивч, хаалтуудыг тослох;<br>2. Лафетны хушууны суурь, түгжээний бэхлэгээг чангалах;<br>3. Лафетны хушууны зарцуулалт болон гаралтын төрөл тохируулагч зэрэг хөдөлгөөнт хэсгүүдийг цэвэрлэж, тослох.    |  |  |
| 5 | Багаж хэрэгслийн хайрцаг, хөшиг, гишгүүр, автомашины шат* | •                     |            |               |         |   |                               | •                   |                              | 1. Гал унтраах багаж хэрэгслийн хайрцагны суурийн бэхлэгээ болон багаж хэрэгслийн бэхлэгээг шалгана;<br>2. Гал унтраах багаж хэрэгслийн хайрцагны хөшиг /хаалт/-ний гүйдэг зам, түгжээ, хийн гүрш, ороомог, жийрэг, бариулын бүрэн бүтэн байдал, ажиллагааг шалгана;<br>3. Гал унтраах автомашины багаж хэрэгслийн хайрцаг, шатны гишгүүрийн бэхлэгээ, нугас, түгжээг шалгана.   |                  |         |            |  |         |   |                              |                               |                     |                 |                  |  | 1. Гал унтраах багаж хэрэгслийн хайрцагны суурь, гишгүүр, хөшигний бэхлэгээг чангалах;<br>2. Гал унтраах багаж хэрэгслийн хайрцагны хөшиг /хаалт/-ний гүйдэг зам, түгжээ, ороомог, жийрэг, гишгүүрийн нугас, гүйдэг болон гулсаг тавиурын зам, шатны нугас зэрэг хөдөлгөөнд эд ангиудыг тослох;  |  |  |  |
| 6 | Гар хушуу   | •                     |            |               |         |   |                               | •                   |                              | 1. Гар хушуунд хагарсан, цуурсан гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана;<br>2. Гар хушууны эргэх хэсгүүдийн хөдөлгөөн, жийрэг резинүүдийн битүүмжлэлийг шалгана;<br>3. Гар хушууны зарцуулалт, гаралтын төрөл тохируулагчийн ажиллагаа, хаалтыг шалгана;<br>4. Гар хушууг техникийн үзүүлэлтэд заасан ажлын дундаж даралтаар 1 минутаас багагүй хугацаанд ажиллуулж шалгана. (Ажлын даралт дунджаар 4-8 бар)   |                  |         |            |  |         |   |                              |                               |                     |                 |                  |  |  | 1. Гар хушууны жийрэг резин, хаалт (бөмбөлөг гэх мэт)-ыг цэвэрлэж, тослох;<br>2. Гар хушууны зарцуулалт, гаралтын төрөл тохируулагчийг цэвэрлэж, тослох.   |  |  |



|    |  |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |   |   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  |   |  |   |  |  |  |  |  |  |   |  |   |  |   |   |
|----|--|---|--|--|---|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|---|---|---|--|--|---|--|--|--|--|--|--|--|---|---|--|---|--|---|--|--|--|--|--|--|---|--|---|--|---|---|
| 23 | Моторт хөрөө - объектын гал түймрийн задаргааны*         | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Механик гэмтэл үүссэн эсэхийг гадна үзлэг хийж шалгана;<br>2. Агаарын хаалт, асаах, унтраах товч, моторын эргэлт тохируулга зэргийн ажиллагааг шалгана;<br>3. Шатахуун, тосны түвшин, баттарыны цэнэгийг шалгана;<br>4. Гинжний тосолгоо, чанга, сул байдлыг шалгана;<br>5. Хөрөөг ажиллуулан моторын эргэлтийг нэмж, хасах байдлаар шалгана;<br>6. Гинжний ирийг ашиглах боломжтой материалд туршиж шалгана.   | •   |   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   | 1. Агаарын болон шатахууны шүүрийг цэвэрлэх, шаардлагатай үед солих;<br>2. Шатахуун, тосны савыг цэвэрлэх;<br>3. Цилиндрийн гадна бохирдлыг цэвэрлэх;<br>4. Дуу намгагч, оч баригчийг цэвэрлэх, шаардлагатай үед солих;<br>5. Тосолгоо хийх;<br>6. Очлуурыг цэвэрлэх, шаардлагатай үед солих. |  |   |  |   |  |  |  |  |  |  |   |  |   |  |   |   |
| 24 | Цахилгаан мотор бүхий тасдагч хэрэгсэл /дисктэй/*        | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Механик гэмтэл үүссэн эсэхийг гадна үзлэг хийж шалгана;<br>2. Агаарын хаалт, асаах, унтраах товч, моторын эргэлт тохируулга зэргийн ажиллагааг шалгана;<br>3. Шатахуун, тосны түвшин, баттарыны цэнэгийг шалгана;<br>4. Ирний бэхлэлт, чанга, сул байдал, ирний хамгаалалтын хаалтын бүрэн бүтэн байдлыг шалгана;<br>5. Тасдагчийг ажиллуулан моторын эргэлтийг нэмж, хасах байдлаар шалгана;<br>6. Тасдагчны ирийг ашиглах боломжтой материалд /хар цаас, мод гэх мэт/ туршиж шалгана. | •   |   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  | 1. Агаарын болон шатахууны шүүрийг цэвэрлэх, шаардлагатай үед солих;<br>2. Шатахуун, тосны савыг цэвэрлэх;<br>3. Цилиндрийн гадна бохирдлыг цэвэрлэх;<br>4. Тосолгоо хийх;<br>5. Очлуурыг цэвэрлэх, шаардлагатай үед солих. |   |  |   |  |   |  |  |  |  |  |  |   |  |   |  |   |   |
| 25 | Төмөр, болт тасдагч гар багаж                            | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Хагарсан, цуурсан, эмтэрсэн гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана;<br>2. Тасдагчны ирны бүрэн бүтэн байдлыг шалгана;<br>3. Техникийн үзүүлэлтэд заасан тохирсон хэмжээний диаметртай хадаас, боолт зэргийг тасдаж шалгана;<br>4. Нугас болон зориулалтын бариулын бүрэн бүтэн байдлыг шалгана.   | •   |   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   | 1. Тасдагчны хөдөлгөөнт гол, нугасыг цэвэрлэх, тослох;<br>2. Тасдагчны хөдөлгөөнт гол, нугасыг эрэг боолтыг чангалах.   |  |   |  |   |  |  |  |  |  |  |   |  |   |  |   |   |
| 26 | Багор, дэгээ, царил, сэрээ, лантуу, сүх, жоотуу, хүрз    |   |  |  | • |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Хагарсан, цуурсан, эмтэрсэн, гулзайсан гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана;<br>2. Ир, үзүүрийн чанар байдлыг шалгана;<br>3. Зориулалтын бариулын бүрэн бүтэн байдлыг шалгана.  | •   |   |   |  |  | • |  |  |  |  |  |  |  |   |   | 1. Шаардлагатай багаж, хэрэгслийн ир, үзүүрийг хурцлах;<br>2. Багаж, хэрэгслийн иш, бариулын бэхлэлт чангалах. |   |  |   |  |  |  |  |  |  |   |  |   |  |   |   |
| 27 | Лебедка /татагч хэрэгсэл/*                               |   |  |  | • |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Механик гэмтэл үүссэн эсэхийг гадна үзлэг хийж шалгана;<br>2. Лебедканы түгжээг шалгана;<br>3. Удирдлага, залгуурын бүрэн бүтэн байдлыг шалгана;<br>4. Лебедканы ороох хэсгийн тосолгоо, троссны бүрэн бүтэн байдлыг шалгана;<br>5. Лебедканы моторыг ажиллуулан татах, суллах байдлаар шалгана;<br>6. Лебедканы суурь болон бэхлэлт шалгана.   | •   |   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  | 1. Лебедканы эргэх хэсгүүдэд тосолгоо хийнэ;<br>2. Лебедканы моторыг ажиллуулан татах, суллах байдлаар шалгана;<br>3. Лебедканы троссыг бүрэн дэлгэж цэвэрлэж, тосолгоо хийнэ;<br>4. Лебедканы суурь болон бэхлэлт шалгана. |  |   |  |  |  |  |  |  |   |  |   |  |   |   |
| 28 | Цахилгаанаас хамгаалах гутал                             |   |  |  | • |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Урагдсан, цоорсон, эмтэрсэн гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана /Цахилгаан хүчдэлээс хамгаалах үзүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар шалгуулна/.   | •   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  |   |  |   |  |  |  |  |  |  |   |  |   |  |   |   |
| 29 | Цахилгаанаас хамгаалах бээлий                            |   |  |  | • |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |   | 1. Урагдсан, цоорсон, эмтэрсэн гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана /Цахилгаан хүчдэлээс хамгаалах үзүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар шалгуулна/. | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  |   |  | 1. Бээлий, гутал, гишүүрийг цэвэрлэж, үзлэг шалгалт хийсэн тухай тэмдэглэгээ хийнэ. |  |  |  |  |  |  |   |  |   |  |   |   |
| 30 | Цахилгаанаас хамгаалах шалавч, гишүүр                    |   |  |  | • |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |   | 1. Урагдсан, цоорсон, эмтэрсэн гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана /Цахилгаан хүчдэлээс хамгаалах үзүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар шалгуулна/. | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  |   |  |   |  |  |  |  |  |  |   |  |   |  |   |   |
| 31 | Цахилгаан тасдагч хайч*                                  | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Хагарсан, цуурсан, эмтэрсэн гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана;<br>2. Тасдагчны ирны бүрэн бүтэн байдлыг шалгана;<br>3. Техникийн үзүүлэлтэд заасан тохирсон хэмжээний диаметртай цахилгааны утас /тэжээлд холбогдоогүй-ыг тасдаж шалгана;<br>4. Нугас болон зориулалтын бариулын бүрэн бүтэн байдлыг шалгана.<br>/Цахилгаан хүчдэлээс хамгаалах үзүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар шалгуулна/.        | •   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  |   |  |   |  |  |  |  |  | 1. Тасдагчны хөдөлгөөнт гол, нугасыг цэвэрлэх, тослох;<br>2. Тасдагчны хөдөлгөөнт гол, нугасыг эрэг боолтыг чангалах.  |   |  |   |  |   |   |
| 32 | Цахилгаан хэмжигч, мэдрэгч                               | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Хагарсан, цуурсан, эмтэрсэн гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана;<br>2. Мэдрэгчийн батареийг шалгана;<br>3. Техникийн үзүүлэлтэд заасан тохирсон хэмжээний хүчдэлтэй хэрэгсэлд туршиж шалгана;<br>4. Аюулгүй байдлыг хангасан бариулын бүрээс, иж бүрдлийг шалгана.<br>/Цахилгаан хүчдэлээс хамгаалах үзүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар шалгуулна/.   | •   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  |   |  |   |  |  |  |  |  | 1. Мэдрэгч, хэмжигчийн батареийг цэвэрлэх, шаардлагатай бол солих;<br>2. Мэдрэгч, хэмжигчийн бариул, аюулгүйн бүрээсийн бэхлэлт чангалж, бүрэн бүтэн байдлыг хангах. |   |  |   |  |   |   |
| 33 | Хайгуулын ажиллагааны чиглүүлэгч тросс, олт*             | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Тросс, олсонд сэмэрсэн, нугарсан, тасарсан зэрэг механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана;<br>2. Хайгуулын тросс, олсны уртын хэмжээг шалгана;<br>3. Хайгуулын тросс, олсны дамарны хэвийн ажиллагааг шалгана;<br>4. Хайгуулын тросс, олсны аврагч, гал сөнөөгчтэй карбинаар холбогдох холболтыг шалгана.  | •   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  |   |  |   |  |  |  |  |  |  | 1. Тросс, олсыг цэвэрлэж, тосолгоо хийх;<br>2. Хайгуулын тросс, олсыг бүрэн дэлгэж, дамарыг тослох, чангалах; |  |   |  |   |   |
| 34 | Аврах олт *  | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Олсонд сэмэрсэн, урагдсан зэрэг механик гэмтэл үүссэн эсэх үзлэгийг 10 хоног тутам болон ажиллагааны өмнө болон дараа хийнэ;<br>2. Олсны уртын хэмжээ (суналт үүссэн эсэх)-г шалгана;<br>3. Нэг удаа тухайн олсны техникийн үзүүлэлтэд заасан хэмжээний /Дунджаар 350 кг/ ачааг 5 минутын хугацаатай дүүжилж туршина. Туршилтын дараа олсонд ямар нэгэн гэмтэл илрэхгүй, урт нь анхны уртаас 5 хувиас хэтрээгүй байвал зохино. | •   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  |   |  |   |  |  |  |  |  |  |   |  | 1. Олсны бүрэн дэлгэн, эвхэлтийг сольж, цэвэрлэх. |  |   |   |
| 35 | Утаа сорогч, зайлуулагч*                                 | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Сэнс, хамгаалалтын тор гэмтэх гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг гадна үзлэг хийж шалгана;<br>2. Агаарын хаалт, асаах, унтраах товч, моторын эргэлт тохируулга зэргийн ажиллагааг шалгана;<br>3. Шатахуун, тосны түвшин, баттарыны цэнэгийг шалгана;<br>4. Төхөөрөмжийг ажиллуулан моторын эргэлтийг нэмж, хасах байдлаар шалгана.  | •   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  |   |  |   |  |  |  |  |  |  |   | 1. Сэнс, хамгаалалтын тор, суурийн бэхлэлт зэргийг чангалах;<br>2. Шатахууны сав, батареийг цэвэрлэх;<br>3. Тосны түвшинг нэмж, шаардлагатай үед солих;<br>4. Очлуурыг цэвэрлэх, шаардлагатай үед солих. |   |  |   |   |
| 36 | Төрөл бүхийн хий мэдрэгч*                                | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Хагарсан, цуурсан, эмтэрсэн гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана;<br>2. Мэдрэгчийн батареийг шалгана;<br>3. Техникийн үзүүлэлтэд заасан хий мэдрэх ажиллагааг мэргэжлийн хэмжилт хийх эрх бүхий байгууллагаар шалгуулна.   | •   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  |   |  |   |  |  |  |  |  |  | 1. Мэдрэгчийн батареийг цэвэрлэх;<br>2. Мэдрэгчийн гуурс болон их биеийг цэвэрлэх.                            |  |   |  |   |   |
| 37 | Гал унтраах автомашины төрөл бүрийн гэрэлтүүлэх хэрэгсэл | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Хагарсан, цуурсан, эмтэрсэн гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана;<br>2. Гэрэлтүүлгийн битүүмжлэлийг шалгана;<br>3. Гэрэлтүүлгийн тусгал, чадалыг шалгана;<br>4. Доргилоос хамгаалсан бүрээс, бэхлэгээний иж бүрдлийг шалгана;<br>5. Гэрэлтүүлгийн тэжээл, батареийг шалгана.   | •   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  |   |  |   |  |  |  |  |  |  |   |  |   |  | 1. Гэрэлтүүлгийн батареийг цэвэрлэх;<br>2. Бэхлэгээ, бүрээс, бариулыг чангална;<br>3. Арчиж цэвэрлэнэ (хүчиллэг бодис ашиглахыг хориглоно). |   |
| 38 | Дулаан мэдрэгч камер *                                   | • |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Хагарсан, цуурсан, эмтэрсэн гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана;<br>2. Мэдрэгч камерын битүүмжлэлийг шалгана;<br>3. Төрөл бүрийн температурын дулаантай биетүүдээр туршиж шалгана;<br>4. Аюулгүй байдал, доргилоос хамгаалсан бүрээс, бэхлэгээний иж бүрдлийг шалгана.  | •   |   |  |  |   |  |  |  |  |  |  |  |   |   |  |   |  |   |  |  |  |  |  |  |   |  |   |  |   | 1. Камерын бэхлэгээ, бүрээс, бариулыг чангална;<br>2. Камерыг бүлэн хэвстэй усаар арчиж цэвэрлэнэ (хүчиллэг бодис ашиглахыг хориглоно). |



|    |   |  |  |  |  |  |  |  |   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |   |
|----|---|--|--|--|--|--|--|--|---|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|--|---|
| 39 | Газардуулагч  |  |  |  |  |  |  |  | 1. Дамжуулах утас, гадас, холболтод механик гэмтэл үүссэн эсэхийг үзлэг хийж шалгана;<br>2. Дамжуулагч утасны бүрээсний бүрэн бүтэн байдлыг шалгана.<br>/Газардуулагчийн эсэргүүцлийг мэргэжлийн байгууллагаар шалгуулна/.  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Дамжуулах утсыг бүрэн дэлгэж, утас, холболт, гадас зэргийг цэвэрлэнэ. |  |  |   |
| 40 | Толгой хамгаалах хэрэгсэл-<br>объектын гал түймэр<br>/дуулга/     |  |  |  |  |  |  |  | 1. Механик гэмтэл үүссэн эсэхийг гадна ерөнхий үзлэг хийж шалгана;<br>2. Нүүрний хаалтны харагдац, тунгалага байдлыг шалгана;<br>3. Дотоод тоноглол, зөөлөвчийн бэхлэгээ, бүчийг шалгана;<br>4. Хүзүүний хаалт, гар чийдэн, нүүрвэч масны суурийг шалгана;<br>/Дорилт, цохилтын болон дулааны үйлчлэлийн туршилтыг тусгай лабораторит хийнэ/.   |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Их бие, нүүрвэч, хүзүүвч, бэхлэгээ, хамгаалалт зэргийг савантай бүрэн усаар цэвэрлэх (гөрлө бүрийн хүчиллэг болон спиртийн агууламж өндөртэй бодис ашиглах хористой);<br>2. Хүзүүний хаалт, гар чийдэн, нүүрвэч маск, хамгаалалтын зөөлөвчийн бэхлэгээг чангална. |  |   |
| 41 | Гал сөнөөгчийн бүс *  |  |  |  |  |  |  |  | 1. Механик гэмтэл үүссэн эсэхийг гадна ерөнхий үзлэг хийж шалгана;<br>2. Бүсний арал, гогцоо, карбины бүрэн байдлыг шалгана;<br>3. Бүсний их биеийн урагдсан, смэрсэн эсэх, бүрэн бүтэн байдлыг шалгана;<br>4. Аврах бус болон карбинаас техникийн үзүүлэлтэд заасан жин /дундаж үзүүлэлт 350 кг/-тай ачааг 5 минутын турш зүүж шалгана. Туршилтын дараа бүс, карбинд ямар нэгэн гэмтэл илрэхгүй байвал зохино.                                       |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Бүсний бэхлэгээ, гогцоо, түгээ зэргийн чангалгааг хийж, цэвэрлэнэ.  |   |
| 42 | Карбин*   |  |  |  |  |  |  |  | 1. Механик гэмтэл үүссэн эсэхийг гадна ерөнхий үзлэг хийж шалгана;<br>2. Бүсний арал, гогцоо, карбины бүрэн байдлыг шалгана;<br>3. Бүсний их биеийн урагдсан, смэрсэн эсэх, бүрэн бүтэн байдлыг шалгана;<br>4. Аврах бус болон карбинаас техникийн үзүүлэлтэд заасан жин /дундаж үзүүлэлт 350 кг/-тай ачааг 5 минутын турш зүүж шалгана. Туршилтын дараа бүс, карбинд ямар нэгэн гэмтэл илрэхгүй байвал зохино.                                       |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |   |
| 43 | Байлдааны сүх   |  |  |  |  |  |  |  | 1. Цуурсан, гулзайсан гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг гадна ерөнхий үзлэг хийж шалгана;<br>2. Сүхний бариулын бүрээсний бүрэн байдал, зурамтгай чанарыг шалгана;<br>3. Сүхийг хэвтээ байрлалд байрлуулан 80-100кг ачааг зүүж гулзайлтын байдлыг шалгана. Туршилтын дараа сүхэнд ямар нэгэн гэмтэл илрэхгүй байвал зохино.   |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Сүхийн ир, үзүүрийг хурцлах;<br>2. Иш, бариулын бэхлэгээг чангалах.   |  |   |
| 44 | Толгой хамгаалах хэрэгсэл -<br>ой, хээрийн гал түймэр<br>/дуулга/ |  |  |  |  |  |  |  | 1. Механик гэмтэл үүссэн эсэхийг гадна ерөнхий үзлэг хийж шалгана;<br>2. Нүүрний хаалтны харагдац, тунгалаг байдлыг шалгана;<br>3. Дотоод тоноглол, зөөлөвчийн бэхлэгээ, бүчийг шалгана;<br>4. Хүзүүний хаалт, гар чийдэнгийн суурийг шалгана;<br>/Дорилт, цохилтын болон дулааны үйлчлэлийн туршилтыг тусгай лабораторид хийнэ/.   |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Их бие, нүүрвэч, хүзүүвч, бэхлэгээ, хамгаалалт зэргийг савантай бүрэн усаар цэвэрлэх (гөрлө бүрийн хүчиллэг болон спиртийн агууламж өндөртэй бодис ашиглах хористой);<br>2. Хүзүүний хаалт, гар чийдэн, нүүрвэч маск, хамгаалалтын зөөлөвчийн бэхлэгээг чангална. |  |   |
| 45 | Үлээгч аппарат*   |  |  |  |  |  |  |  | 1. Механик гэмтэл үүссэн эсэхийг гадна үзлэг хийж шалгана;<br>2. Агаарын хаалт, асаах, унтраах товч, моторын эргэлт тохируулга зэргийн ажиллагааг шалгана;<br>3. Шатахуун, тосны түвшин, баттарыны цэнэгийг шалгана;<br>4. Эрэг, боолтын чангалгааг шалгана;<br>5. Үлээгчийг ажиллуулан моторын эргэлтийг нэмж, хасах байдлаар шалгана;<br>6. Үлээгчийн үүргэвч, мөрөвч зэрэг иж бүрдлийг шалгана.  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Агаарын болон шатахууны шүүрийг цэвэрлэх, шаардлагатай үед солих;<br>2. Шатахуун, тосны савыг цэвэрлэх;<br>3. Цилиндрийн гадна бохирдлыг цэвэрлэх;<br>4. Дуу намгагч, оч баригчийг цэвэрлэх, шаардлагатай үед солих;<br>5. Тосолгоо хийх;<br>6. Очлуурыг цэвэрлэх, шаардлагатай үед солих.   |
| 46 | Цуравдагч *   |  |  |  |  |  |  |  | 1. Их бие, хушуунд гулзайлт гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг гадна үзлэг хийж шалгана;<br>2. Шатахууны савны амьсгалын клапаны хэвийн байдлыг шалгах;<br>3. Цуравдагч хушууны бамбарын бүрэн бүтэн байдлыг шалгана.  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Их бие, хушуунд цэвэрлэгээ хийх;<br>2. Шүүр, цоргыг цэвэрлэх, шаардлагатай үед солих;<br>3. Бамбарыг шаардлагатай бол солих.  |  |   |
| 47 | Үүргэвчин ус шүршигч  |  |  |  |  |  |  |  | 1. Их бие, хушуунд гулзайлт гэх мэт механик гэмтэл үүссэн эсэхийг гадна үзлэг хийж шалгана;<br>2. Хушууны ажиллагааны хэвийн байдлыг шалгана;<br>3. Усны савны битүүмжлэлийг шалгана.   |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Их бие, хушуу, шүүр зэргийг цэвэрлэх;<br>2. Усны савны жийрэг резинүүдийг шаардлагатай бол солих.   |  |   |
| 48 | Моторт хөрөө - ой, хээрийн<br>түймэр *                            |  |  |  |  |  |  |  | 1. Механик гэмтэл үүссэн эсэхийг гадна үзлэг хийж шалгана;<br>2. Агаарын хаалт, асаах, унтраах товч, моторын эргэлт тохируулга зэргийн ажиллагааг шалгана;<br>3. Шатахуун, тосны түвшин, баттарыны цэнэгийг шалгана;<br>4. Гинжний тосолгоо, чанга, сул байдлыг шалгана;<br>5. Хөрөөг ажиллуулан моторын эргэлтийг нэмж, хасах байдлаар шалгана;<br>6. Гинжний ирийг модон материалд түршиж шалгана.  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Агаарын болон шатахууны шүүрийг цэвэрлэх, шаардлагатай үед солих;<br>2. Шатахуун, тосны савыг цэвэрлэх;<br>3. Цилиндрийн гадна бохирдлыг цэвэрлэх;<br>4. Дуу намгагч, оч баригчийг цэвэрлэх, шаардлагатай үед солих;<br>5. Тосолгоо хийх;<br>6. Очлуурыг цэвэрлэх, шаардлагатай үед солих.  |   |
| 49 | Мотопомп*   |  |  |  |  |  |  |  | 1. Механик гэмтэл үүссэн эсэхийг гадна үзлэг хийж шалгана;<br>2. Агаарын хаалт, асаах, унтраах товч, моторын эргэлт тохируулга зэргийн ажиллагааг шалгана;<br>3. Шатахуун, тосны түвшин, баттарыны цэнэгийг шалгана;<br>4. Ажилчин дугуйны бохирдол, бүрэн бүтэн байдлыг шалгана;<br>5. Помпыг ажиллуулан моторын эргэлтийг нэмж, хасах байдлаар шалгана;<br>6. Гараар асаах горимоор асааж шалгана;<br>7. Шатахууны савны амьсгалах клапаныг шалгах. |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Агаарын болон шатахууны шүүрийг цэвэрлэх, шаардлагатай үед солих;<br>2. Илүүдлийн хавхлагыг цэвэрлэх;<br>3. Тосны түвшинг нэмэх, шаардлагатай үед солих;<br>4. Шатахууны савны амьсгалах клапаныг цэвэрлэх;<br>5. Эрэг, боолт, суурь, бэхлэгээг чангалах;<br>6. Орох, гарах хавхлагын хаалт, холболтуудад тосолгоо хийх;<br>7. Очлуурыг цэвэрлэх, шаардлагатай үед солих. |   |
| 50 | Зөөврийн цахилгаан үүсгүүр  |  |  |  |  |  |  |  | 1. Механик гэмтэл үүссэн эсэхийг гадна үзлэг хийж шалгана;<br>2. Агаарын хаалт, асаах, унтраах товч, моторын эргэлт тохируулга, ослын товч зэргийн ажиллагааг шалгана;<br>3. Шатахуун, тос, шингэний түвшин, аккумуляторыг шалгана;<br>4. Үүсгүүрийг ажиллуулан цахилгаан хэрэгсэл холбож шалгана;<br>5. Гараар асаах горимоор асааж шалгана;<br>6. Шатахууны савны амьсгалын клапаны хэвийн байдлыг шалгана.   |  |  |  |  |  |  |  |  |  |  |  |  | 1. Агаарын болон шатахууны шүүрийг цэвэрлэх, шаардлагатай үед солих;<br>2. Илүүдлийн хавхлагыг цэвэрлэх;<br>3. Тосны түвшинг нэмэх, шаардлагатай үед солих;<br>4. Шатахууны савны амьсгалах клапаныг цэвэрлэх;<br>5. Эрэг, боолт, суурь, бэхлэгээг чангалах;<br>6. Цахилгааны холболтуудыг цэвэрлэх;<br>7. Очлуурыг цэвэрлэх, шаардлагатай үед солих. |

\* тэмдэглэгээ бүхий тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг туршин шалгасан тохиолдолд акт үйлдэх ба бусад тохиолдолд хувийн дэвтэрт тэмдэглэл үйлдэнэ.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2023 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн  
А/199 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ .... ДУГААР АНГИ  
АКТ

2023 оны ... дугаар сарын ...-ны өдөр

№ .....

Улаанбаатар хот

Тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл  
туршин шалгасан тухай

1. Тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн нэр:

.....

2. Загвар:

.....

3. Серийн дугаар:

.....

4. Үйлдвэрлэсэн он: .....

5. Туршин шалгасан огноо: ..... он ..... сар ..... өдөр, Эхэлсэн цаг: ..... Дууссан цаг: .....

6. Шалгалтын зорилго: /хуваарийн дагуу, техникийн үйлчилгээ, засвар хийсний дараа гэх мэт/

.....

7. Хэрхэн шалгасан тухай:

.....

.....

8. Илэрсэн эвдрэл, гэмтэл, засварласан байдал:

.....

.....

Шаардлага хангасан эсэх:

Засварлах боломжтой эсэх:

Хангасан  Хангаагүй

Боломжтой  Боломжгүй

9. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

.....

ТУРШИН ШАЛГАСАН АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ: .....

ГИШҮҮД: .....

.....

.....

.....

.....

ХЯНАСАН :

.....